

Хөдөөг интернетжүүлсэн нь

Фермер Жон хотын даргаар сонгогджээ. Тэрээр мөрийн хөтөлбөртөө тойргийнхоо бүх фермүүдэд интернэтийн холболт тавина гэж амлажээ. Түүнд чиний тусламж хэрэгтэй байгаа.

Фермер Жон өндөр хурдны холболт өөрийн фермдээ тавиулахаар захиалсан бөгөөд үүнийгээ бусад фермүүдтэйгээ хуваах юм. Тэрээр зардлаа хамгийн байлгахын тулд ферм хооронд тавих шилэн кабелийнхаа хэмжээг хамгийн бага байлгахыг зорьж байна.

Хос ферм бүрийг холбоход хир их шилэн кабель орохыг үзүүлсэн жагсаалт өгөгдөх бөгөөд чиний даалгавар бол тэдгээрийг бүгдийг нь холбоход хамгийн багадаа ямар хэмжээний кабель хэрэгтэйг олох. Дурын фермээс дурын ферм рүү өгөгдөл дамжиж болохоор ферм бүр бусад фермтэйгээ холбогдсон байх ёстой.

Аль ч хоёр фермийн хооронд дахь зай 100,000 хэтрэхгүй.

Програмын нэр: agrinet

Оролтын Формат

1 мөр:	Фермүүдийн тоо, N ($3 \leq N \leq 100$).
Удаахь мөрүүд:	Дараагийн мөрүүдэд $N \times N$ хэмжээтэй матриц байна. Элемент бүр нь 2 фермийн хооронд дахь зайг үзүүлнэ. Логикын хувьд N ширхэг зайгаар тусгаарлагдсан бүхэл тооноос бүтэх N ширхэг мөр байна. Мөрийн урт нь 80 тэмдэгтээр хязгаарлагдана. Диагональ нь 0 байна. Учир нь фермээс өөр рүү нь явах нь 0 юм.

Жишээ оролт (файл agrinet.in)

4

0 4 9 21

4 0 8 17

9 8 0 16

21 17 16 0

Гаралтын Формат

Гаралтанд бүх фермүүдийг холбоход шаардагдах шилэн кабелийн хамгийн бага хэмжээг илэрхийлэх нэг бүхэл тоо байна.

Жишээ гаралт (файл agrinet.out)

28

Орчуулсан : Б.Даваабаяр